



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 7/42

Мандалговь

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн 48 дугаар зүйлийн 2.2, 50 дугаар зүйлийн 50.1 дахь хэсэг, 50.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвөөс санхүүжих сумдын эрүүл мэндийн төвүүдийн эмнэлэгт шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Х.Чирчинсүрэн (Уламжлалт Анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн дарга)

Үнэлгээний хорооны нарийн бичиг:

О.Урансоёл (Эмийн хангамж, эрүүл мэндийн тусгай зөвшөөрөл, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй хариуцсан мэргэжилтэн)

Үнэлгээний хорооны гишүүд:

Г.Отгонгонгор (Сайнцагаан эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч)

Э.Уугандаваа (Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн нягтлан бодогч)

Э.Мөнхзол (Иргэний төлөөлөл)

2. Үнэлгээний хороог байгуулагдсанаас хойш ажлын 2 хоногийн дотор хуралдуулж тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Х.Чирчинсүрэн)-д үүрэг болгосугай.

3. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, архивын баримт хариуцсан ажилтанд хүлээлгэн өгөхийг нарийн бичгийн дарга (Урансоёл)-д даалгасугай.

ДАРГА

Б.АЛТАНТӨГС

